

**XX ЗУУНЫ ЭХЭН ҮЕ БА XXI ЗУУНЫ ЭХЭН ҮЕИЙН НИЙГМИЙН БАЙДАЛ,
ЯРУУ НАЙРАГ, ШИНЭЧЛЭЛ, ХЭЛНИЙ ЗАРИМ АСУУДАЛ**

Д. Галбаатар*

Монголын орчин үеийн яруу найргийн түүхийг 1921 оны хувьсгалын дуунуудаар эхэлсэн гэж ярьж хэвшжээ. Үнэндээ XX зууны яруу найраг тэр дундаа дууны агуулга, хэлний асуудлыг 1911 оны Үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний ялалт, түүнээс өмнө үеийн уламжлалтай ямагт холбож үзэх нь илүү сонирхолтой, бодтой үнэлэлт дүгнэлт хийх боломж олгох талтай.

Аливаа үндэстний уран зохиолын хөгжил нь нийгмийн өөрчлөлт, түүхийн шилжилттэй уялдаж агуулга, үзэл санаа, хэлэнд нь томоохон өөрчлөлт гардаг зүй тогтолтой бол харин туурвил зүйн шинэ хэлбэршил, арга барил төлөвших явц удаан хугацаанд үргэлжилж, хувьслын явцдаа хуучин уламжлалыг эвдсэн шинэ жанруудыг бий болгодог. Ялангуяа ур зүй, хэл хийгээд бусад хүчин зүйлийн нөлөөллөөс шалтгаалан дууны ая дан, хэлбэр, дуулагдах байдалд орчин үеийн техник-технологийн шинэтгэлтэй уялдан шинэчлэгдэх зайлшгүй гэмээр хэрэгцээ гарч ирдэг. Үүнээс шалтгаалан дууны агуулга, хэлний үүрэг, найруулгын өнгө аяс, ая дан, хэмнэл хэмжээнд өөрчлөлт орох төдийгүй дууны шүлгийн хэлэнд ч асар их өөрчлөлт оруулдаг. Нэлээд тохиолдолд хэлний бүтцийг эвдэх, найруулгыг сулруулах, гадаад хэлний нөлөө ихсэх, үндэсний төдийгүй уран сайхны хэлний хөгжим аялгуу, хэмнэл, яруу сайхан чанарт сөргөөр нөлөөлөх үзэгдэл эрчимждэг. Үүнийг нэг талаас хэлний хэм хэмжээ, үндэсний хэлний цэвэр байдлыг хангах талаасаа буруутгах олон шалтгаан буй ч, урлагийнх нь хувьд ор тас үгүйсгэх боломжгүй шинэ үзэгдэл байх нь элбэг юм.

XX зуунд монгол яруу найргийн хөгжилд хоёр ч томоохон шилжилтийн үе тохиолдсон нь дууны яруу найргийн хөгжил хийгээд хувьсалд шууд нөлөөлсөн билээ. Нөгөө талаар аж төрөх ёсны өөрчлөлт, амьдралын хурд, хэмнэлтэй уялдан, хүмүүсийн танин мэдэхүй, оюун санааны өсөн нэмэгдэж буй эрэлттэй уялдан, урлаг талаасаа дэвшил, уран сайхны хэлний хувьд цэвэр ариун байх тал нь буурах, ядуурах үзэгдлийг дагуулж иржээ. Ялангуяа орчин үеийн урлаг нь улам бүр глобальчлагдаж буй ертөнц дээр техникт технологийн галзуурсан, хурдац, хотжих процесс, аж төрөхүйн түргэн өөрчлөлттэй уялдан улам түргэн өөрчлөгдөж үндэсний хэлний уламжлалт соёл, найруулга, сэтгэлгээ, илэрхийлэх хэв маягт томоохон хувьсал гарчээ.

* МУИС-ийн МХСС-ийн Утга зохиолын тэнхим

Энэ талаар өгүүллийн нэвтрүүлэг дутаар хэсэгт орчин үеийн үндэсний яруу найраг, ялангуяа өнөөгийн дууны үг найруулгын талаар цөөн баримт хөндөж өгүүлнэ.

* * *

Монголчуудын үндэсний эрх чөлөөний хөдөлгөөны түүх XIX зууны төгсгөл, XX зууны эхний 20-иод жилтэй холбогдоно. Чухам энэ үед Монголд хувьсгал гарах нийгэм түүхийн таатай нөхцөл бүрдэж, түүнд ард түмнийг үзэл санааны хувьд бэлтгэхэд хувьсгалт дуунууд чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

“XIX зууны эцсээс монголын ард түмний нийгэм, үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний нөлөөгөөр монголын уран зохиолын ардчилсан дэвшилттэй хандлага гүнзгийрэн хөгжихийн хамт нийт уран зохиолд ертөнцийн ёсыг талархах иргэний шинжийг эрхэмлэх, оршин буй ахуйг шүүмжлэх хандлага нийтлэг болж ирсэн” /“Монголын орчин үеийн уран зохиолын түүх” тэргүүн боть. 1985. 11-р тал/ хэмээн тэмдэглэсэн бөгөөд үүнд хуульч Сандагийн “Үг” буюу ёгт уран шүлэглэл, Р.Хишигбатын нийгэм-гүн ухааны яруу найраг, Гамалын аж байдал, иргэний уянга, Гүлирансын уянгат ба ёгт шүлэг, Б.Гэлэгбалсангийн ерөөл, Лу гүний /Лувсандондов/ байгаль, эх нутгийн уянга, ардын аман яруу найрагийн ардчилсан үзэл санаа, нийтлэлийн чиг хандлага орчин цагийн яруу найргийн шимт хөрс болсон билээ.

1921 оны ардын хувьсгалын өмнө болон дараахан зохиогдсон цөөнгүй дуу бий бөгөөд тэдгээр нь тухайн үеийн уран зохиолд агуулга, үзэл санааны хувьд асар том шинэчлэл хийж эрх чөлөөний тунхаглал, шинэ уран зохиолын ирээдүйн дүр төрхийг тодорхойлсон юм. Тэрхүү наяд илүү жилийн өмнөх дайн байлдаан, дуулиан шуугиант нийгмийн шилжилтийн он жилүүдэд ийнхүү шинэ маягийн уран зохиол бууриа зассан нь XIX зууны сүүлийн хагасаас XX зууны эхний хорин жилийн уран зохиолын хөгжлийн явцаар бэлтгэгдсэн орчин цагийн уран зохиол руу шилжих хөгжлийн түүхэн том үе шат болсон билээ. 1900-аад оноос иргэний ардчилсан уран зохиолын чиглэлийн уламжлалыг барьсан уран үгийн авьяастнуудын бүтээлийг 1920-иод он хүртэл хуучин цагийн боловсролтой, эх оронч сэхээтнүүд үргэлжлүүлж,

1920-иод оны дунд үе гэхэд хувьсгалт уран зохиолын салбарт илтэд шинэчлэлийн салхи сэвэлзэж, шинэ туршилт оролдлогууд хийгдэж, томоохон төлөөлөгч болох шинэ яруу найрагч, зохиолчид төрж уран зохиолын өнгө төрх, урлал зүй, агуулга, үзэл санаа, хэлбэрт томоохон эргэлт хийж чадсан билээ. Уран зохиолын шилжилт, шинэчлэлийн эл үзэгдэл нь өөр бусад үзэгдэл, үйл явцын нэгэн адил эрчимжин хөгжих, бууран бүдгэрэх, эргэж сэргэх, бүр мартагдан үгүй болох үзэгдэл хүн төрөлхтний урлагийн түүх, үндэстнүүдийн уран зохиолын хөгжлийн түүхэнд мөнхөд үргэлжилж, орчин хувьсаж өөрчлөгдсөөр иржээ. Үүний нэг нь XX зууны монгол яруу найргийн дэвшил, түүхэн хувьсал байлаа. Тэрхүү шилжилтийн үе шатнаа залуу уран бүтээлчид шашин суртахууны болон ордны дээдсийн хуучин суртал бүхий уран зохиолоос эрс татгалзсан ч шинэ хуучны хоорондын тэмцэл, үзэл онолын зөрөлдөөн, туурвил зүйд хийж эхэлсэн шинэ эрэл туршилтууд нь уран сайхны сэтгэлгээний шинэ онол арга зүй дутмагаас шалтгаалан тухайн үеийн уран зохиолд нэг хэсэг нь эрс шинэчлэл хийх, зарим хэсэг нь төөрөгдөх, хуучнаасаа салж чадахгүй зууралдах үзэгдэл, онол арга зүй, мэдлэг туршлага нимгэн зэргээс шалтгаалан шилжилтийн үйл явц нэлээд хугацаагаар

үргэлжилдэг зүй тогтлоос Монголын орчин үеийн уран зохиолын түүхийн үе шат бүхэн ангид байгаагүй билээ.

Өөрөөр хэлбэл 1930-аад оны сүүл үеийг хүртэлх уран зохиолын өв, туурвил зүйн хэв маяг, найруулгын онцлогийг нийт дорно дахины уран зохиолын ай хүрээнд хамруулан ойлгож эртнээс инагш Хятад, Энэтхэг, төвд, Араб, Персийн утга соёлтой холбоотой байж, харин 1940-өөд оны төгсгөлөөс 1980-аад оны эцэс хүртэл Орос-Европын утга соёлын нөлөө хэв маягийг нэлээд идэвхтэй хүлээж авах нийгэм-түүхийн нөхцөл бүрдсэн төлөв харагддаг. Иймээс монголын орчин үеийн уран зохиолын нэгэн наяд гаруй жилийн түүхийг ерөнхийдөө дорно дахины уламжлалт соёлын хүрэнээнд тэхдээ Орос-Европын бичиг зохиол, уран сайхны соёлын давхар нөлөөнд үндэснийхээ өвөрмөц онцлогийг онцлогийг аль болохоор хадгалахыг эрмэлзсэн уран зохиол гэж болмоор байна.

Орчин цагийн уран зохиолын эхэн үеийг ажиглахад 1921-37 оны хооронд голдуу аман зохиолын арга зүйд шүтсэн богино хэлбэрийн зохиол зонхилж, утга зохиолд хуулбарлах, хэлбэрдэх, бэлгэдэх, загварчлах /үлгэрчлэх/ хийсвэрлэх тэрчлэн сентименталь хийгээд романик хэв шинж бүхий олон арга найруулгыг ашиглаж эрэл хийж, оносон алдсан байдал ч тодорхой харагдаж байна.

Шинэчлэл, шинэ арга зүйн эрэл, чөлөөт сэтгэлгээний хайгуулын энэ үйл явцыг тэргүүлж асан С.Буяннэмэх, М.Ядамсүрэн, Ши.Аюуш... нарын зохиолчдыг улс төрийн хилс хэрэгт холбогдуулан 1937 онд цаазлан, Д.Нацагдорж, Ц.Дамдинсүрэн, Б.Ринчен, Д.Намдаг... зэрэг олон зохиолчийг шорон гянданд хорьж цээрлүүлсний дараа 1937-1948 онуудад уран зохиолын хэвийн үйл явц тасалдаж, дараагийн нэг шинэ үе утга зохиолд орж иртэл уран зохиолд нэг хэсэгтээ л хоосон орон зай үүссэн байна. Хэдийгээр ЗСБНХУ /хуучин/-д “социалист реализм”-ын аргын тухай яриа хөөрөө нэр томъёоны түвшинд /1934/ тодорхойлогдон асан цагт 1939 оны Халх голын, 1945 оны Чөлөөлөх дайн, Баруун хязгаарын тулалдаан зэрэг улс төр, цэрэг дайны таатгүй нөхцөл байдлаас шалтгаалан Зөвлөлтийн “соцреализм”-ын импортчлол удааширч 1948- 1970-аад онд онолын төдийгүй практикийн хувьд монгол уран зохиолд нэвтэрчээ.

Нийгмийн шилжилтийн үеийн ардын дуунууд

Нийгэм цаг үеэ үнэн бодитой, шуурхай тусгадаг яруу найргийн нэг хэлбэр бол дуу юм. 1911 оны эрх чөлөөний хөдөлгөөний ялалтад бэлтгэсэн хэсэг сайхан дуу зохиогдож олон түмний ухамсарт нөлөө үзүүлсэн билээ. Шинэ үе, өөрчлөлт, тусгаар улс болсон баярт үйл явдал нь мөн л өөртөө таарсан улс төр иргэний аяс хандлага бүхий шинэ яруу найргийг ард түмэн өөрсдийн авъяас билгээр аяндаа бий болгосон билээ. Манж Чин улсын хоёр зуу гаруй жилийн ноёрхлыг дуусгавар болгож Богд хаант Монгол улс байгуулсан тэр түүхэн эргэлтийн үед олноо өргөгдөж, төр шашныг хослон барьсан Наран гэрэлт түмэн наст ҮШ богд Жавзандамба хутагт багшдаа зориулсан “Зуун лангийн жороо луус” ёслол хүндэтгэлийн дуу зохиогдож олны дунд их алдаршжээ. Уг дуунд эрх чөлөөт улс болж тусгаар тогтносон хийгээд тэрхүү төр улсынхаа тэргүүнээ итгэл үзүүлж баяссан ардын сэтгэлийн тайтгарал, баяр бахдлыг:

Зуун лангийн жороо луусыг

Зуужин дунд нь хөлөглөв өө хө

Зураг болсон богд ламыгаа

Зонховын ширээнд залав аа хө

зэрэг бадгуудаар илэрхийлж байв.

Цаашид 1917 оны Октябрийн хувьсгалаар унагагдсан оросын цагаантны түрэмгийлэл, халдлага нэмэгдэж, улс орны тусгаар тогтнолд аюул занал учруулах болсон, Хиагтын гурван улсын гэрээ буюу 1919 онд монголын богд хаант төрийг унаган хятадын харааны автономит улс болгон хувиргасан нь нийт монгол туургатны дургүйцлийг төрүүлж, эрс эсэргүүцэл, хурц шүүмжлэлтэй тулгарч олон нийтийн санаа бодол, түүхэн хэргүүдийг дагалдан дууны яруу найраг эрчимтэй хөгжсөн гэж болно.

Энэ үймээнт үеийн тусгал болсон дуу, яруу найргийн бүтээлийн агуулга үзэл санааг ерөнхийд нь гурван хэсэг болгож болно. Үүнд:

1. Хятадын түрэмгий бодлогыг зэвүүцсэн “Гэмин чандруу”, Оросын оргодол хулгай нарыг жигших сэтгэлээ “Барон жанжин” хэмээх дуундаа жанжин байтлаа монгол хүний жигшдэг “шодон сүүлтэй борогч гүү унасан согтуу бароны” шог дүрийг урлан, эзэнт төрийн сүр хүчийг үзүүлэн их хүрэнээ сүүж асан Манжийн амбан Сандогийн монгол орноос шившигтэйгээр хөөгдөн гарсныг элэглэсэн “Өнөөх амбан хаачив аа?”, “Сандо амбан” дуунууд зохиогдсон байна.

Өргөн замыг таглаад байдаг

Өндөр ногоон байшин хаачаа бий даа хө

Өргөн түмнийг жанжлаад байдаг

Өнөө жанаг муудаа өнхрөө бий дээ хө. гэх ба

Замбуутивийг ч жанжлахыг санасан

Залхай амбан зайлаа бизээ хө /Сандо амбан/

хэмээн зэрэг харийн түрэмгийлэгчдийг хөөн зайлуулж, үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний ялалтын уриа цуурай тод сонсдож буй бол эх нутгаасаа дарангуйлагчдын хөөн зайлуулсан ялалтад баярласан ард олны сэтгэлийг илэрхийлсэн улс төр иргэний аяс хандлагатай

Шинэхэн ирсэн Си Лин-бүү нь

Ши-гээ дагаад хөөгдөнө

Шинж муутай гэминг

Шидлийн ёсоор хөөнө

Ай юу зэ юу

Амар сайхан жаргая /Монголын судлал.ҮШ боть. 1971.

117-р тал/ дуу нь Хятадын генерал Шюй Шу жаны дуудагдан буцсан түүхэн үйл явдлын мөрөөр бичигдсэн бололтой /Г.Жамсранжав Уран сайхны ертөнцөд хийсэн сурвалжлага. УБ 1975. 238-р тал/ Ийм дуу олон буй.

2. Мөн Хятадын түрэмгий нартай хуйвалдан монголчуудын олж авсан тусгаар тогтнолыг хятадад сэм худалдсан язгууртнуудын /Богд хаант Монгол улсын бүгд ерөнхийлөн захирах яамны сайд Шанзав Бадамдорж/ үйл хэргийг илчилж, зэвүүцсэн “Магнаг дээлтэй сайдууд гуай” зэрэг олон тооны дуу, шог хошин шүлэг, онч үгс зохиогдож эрх чөлөөний тэмцлийн үзэл санааг дахин сэргээж олон түмний ухамсарт тэмцлийн үзэл санааг бүрдүүлэхэд их нөлөө үзүүлжээ. Эдгээр дуунаас зохиолч С.Буяннэмэхийн “Таван мөнгө хүрэхгүйгээр түмэн ардаа худалдсан халхыг ноёд” /1920/

дуу хувьсгалт тэмцлийн цаашдын өрнөл хөгжилт олон түмний ухамсрыг сэргээх, хувьсгалд бэлтгэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Зохиолчийн дээрх дууны үг “одоо хэр бичмэлээр олдоогүй байна” /Монголын уран зохиолын дээжис. УБ. 1997. 6-р тал/ Харин “Магнаг дээлтэй сайдууд гуай” дуунд:

Богц богц мөнгөөр
Богдыгоо худалдсан сайдууд гуай
Хүүдий хүүдий мөнгөөр
Хүрээгээ худалдсан сайдууд гуай гэх ба

Хүрэн улаан хормогчтой сайдууд гуай
Хүрээгээ худалдаад эялайв уу?
Магнаг эрээн дээлтэй сайдууд гуай
Манийгаа худалдаад гялайв уу? хэмээн дуулдаг.

Мөн гэмин цэргийн харгис хэрцгий шинж, догшин авир болоод Богд гэгээнийг барьж хорьсон тухайд:

Асар хаалга дуугарлаа
Аймшигт гэмин цэрэг
Арзайсаар орж ирээд
Аашлан зандран цовхорч байлаа...

хэмээн зэвүүцэн угтсан цаг үеийн амьсгалыг мэдэрч болох юм. Эдгээр ардын дуунд “1.Харийн булаан эзлэгчдийн түрэмгийллийг эсэргүүцсэн, 2.Гадаадын дайсны гар хөл болсон дотоодын хар шар феодал, шавь хамжлагийн эздийн үнэн байдлыг илчилж” /Д.Цэдэв Хувьсгалын сэдэвт дуунууд дахь ардын дууны уламжлалын асуудалд. УБ 1978 33-р тал/ байсан нь “Шивээ хиагт”, “Улаан туг”, “Магнаг үсэгтэй туг” ардын хувьсгалын сэдэвт дуунууд гарахад үзэл санааны дэвшилтэт уламжлал болсон гэж үздэг.

3. Энэ түүхэн үеийн улс төр иргэний яруу найргийн дотор эрх чөлөөний төлөө тэмцэн босч гавьяа байгуулсан олон тооны язгууртнууд өндөр хэргэм цол хүртсэн хийгээд тэдний бүхий л тэмцэл эрх чөлөө, тусгаар тогтнолоо дахин алдсантай холбоотой зохиогдсон санаа сэтгэл алдарсан, гуниг цөхрөлөө илэрхийлсэн, үндэсний үзэлтэй эх оронч сэхээтнүүдийн ганирхалт байдлыг илтгэсэн олон тооний дуу зохиогдсон нь ерөнхийдөө сентименталь яруу найргийн хэв төрхийг хадгалсан, утга уянгын дууны хэлбэршил болж гарч иржээ. Эдгээр нь XIX зууны туршид дарлал мөлжлөгийн дор ядарч зүдэрсэн ард олны оюун санаагаар бэлтгэгдсэн улс төр, утга уянгын яруу найргийн хөгжлийн зүй ёсны үе шат байлаа. Эдгээрээс “Ум зандан ширээ”, “Саатай тоорцог”, “Үзмээр нэрсэн архи”, “Байцаа гэдэг ногоо”, “Лоолой лоолой”, “Мэлхий мэлхий”, “Цонхон дээр суусан ялаа” зэрэг энгийн харахад ахуй байдлын илэрхийлэл мэт боловч далд битүү, ёгт агуулгатай, уйтгар гуниг, цөхрөл гутралын аястай утга уянгын яруу найргийн сонирхолтой туурвилуудаар баяжсан байна. Нийгэм түүхийн иймэрхүү нөхцөл байдал үүнээс өмнөхөн феодализмаас капитализмд шилжиж асан үед өрнө дахины уран зохиолд сентименталист чиглэл үүсч, эгэл дундаж, доод анги давхрагынхны уян зөөлөн сэтгэл, уй гуниг, харуусал уярал, нийгэм болон иргэний өдөр тутмын залхаг ахуй, доромжлогдсон байдлыг илтгэн яруу найргийг уянгын чиглэлд гүнзгийрүүлсэн бөгөөд энэ мэт өнгө аяс, яруу илэрхийллүүд энэ үеийн монгол яруу найрагт тод тусгалаа олсон байна.

Манай зарим судлаачид “...зэрэг завхай дуу шүлгүүд нэлээд зохиогджээ” /”Утга зохиол шинжлэл” /анхдугаар хэвлэл/ МУБИС. УБ 2005. 157-р тал/ гэж үзэж байна. Үүнтэй холбоотой зарим тайлбар хийх нь зүйтэй билээ. Өрнө дахин төдийгүй дорно дахины орнуудад ч “завхай” дуу хэмээх ойлголтод завхай зайдан явдал, садар самуун, бэлгийн харилцааны сэдэвтэй, тэдгээрийг хамаа намаагүй, ил тод сурталчилсан зохиолуудыг нэрлэж заншжээ. Өрнөдөд “шансонет” /зугаацал наргиа, алиг шалиглалын дуу/ гэдэг. Харин дээрх дуунууд нь нийгэм ороо бусгаа байдалд сэтгэл алдарсан, ирээдүйн сайхныг хүсэн мөрөөдсөн, цаг үеэ шүүмжилсэн ёгт хэлбэр, сэтгэлийн уянгын галбир сэлтээрээ дээр өгүүлсэн “завхай” дууны төрөлд бус харин сентименталь хэв шинжийн урлалд хамаарах билээ.

Богд хаант Монгол улс байгуулагдсан хийгээд тусгаар тогтнолоо эвдүүлсэн түүхийн эгзэгтэй үед бүтээгдсэн эдгээр дуунууд нь 1911-1920-иод оны яруу найргийн хөгжлийн нэг чухал үе шат болсон юм. Ард түмний сэтгэл санааны байдал, үзэл санааны зөрчилт тал, нийгмийн хямралын нөхцөл дэх хүний сэтгэлийг шинжлэхэд чухаг хэрэглэгдэхүүн төдийгүй монгол яруу найргийн нэгэн үеийн түүх, ур чадвар, сэтгэлгээний хэв маяг, үзэл санааны өөрчлөлтийг тусгасан нийгмийн шилжилтийн үеийн онцлогийг тусгасан томоохон шинэчлэл болсноороо ач холбогдолтой юм.

Ийнхүү 1910-1920-иод оны дууны яруу найргийн хөгжлийн зүй ёсны үргэлжлэл, үзэл санааны шинэтгэл нь 1921 оны ардын хувьсгалын өмнөхөн ба хувьсгалын үе шат, түүний дараа үеийн дуунуудаар баяжин шинэчлэгдэж иржээ. Аливаа юм бүхэнд эх үндэс гэж бий. Эдгээр дуунууд шинэ уран зохиолын уламжлал болсон бүтээлүүд юм.

* * *

1980-аад оны сүүл 1990-ээд онд Монгол улсад социализмаас, ардчилсан ёсны нийгэм рүү шилжих хувьсгалт үйл явц өрнөх нийгэм түүхийн таатай нөхцөл байдлыг бүрдүүлсэн билээ. Үүнтэй уялдан социалист реализмын зарчим зүй эвдэрч зах, зээлийн харилцаанд шилжих үйл явц идэвхжин, сэтгэлгээний шинэтгэл чөлөөт байдал бий болсон нь уран зохиол, ялангуяа яруу найрагт томоохон өөрчлөлт шинэ туршилтуудыг бий болгож, нөгөө талаас шүлэг зохиолыг үнэлэх хуучин үнэлэмж, түүнд тавих анхаарал суларсан, нийгэмд хуучин хориотой, хориглодог, хөрөнгөтний зэргээр хаалттай асан уран зохиолын урсгал чиглэл, шүлэг дууны шинэ төрөл хэлбэрүүд нэвтэрснээр эерэг, сөрөг хоёр туйлшралыг бий болгож, энэ нь дууны яруу найраг, түүний хэлний хэм хэмжээг нэг талаас эвдсэн, нөгөө талаар дууны урлагийн шинэ төрөл хэлбэршил /хип хоп, рок, поп, бүр хиппи урлагийн олон урсгалууд орж ирсэн/-үүд, уламжлалт дууны яруу найргийн шүлгийн сонгодог уламжлалт тогтолцоог алдагдуулах, үнэ цэнгүйдүүлэх сөрөг нөлөө монгол хэлний зүй тогтлыг эвдэх, яруу найргийн хэлний яруу тансаг байдал буурч, найруулах эрдмийн уламжлалт тиг ёс эвдрэх үзэгдэл газар авчээ. Үүний учир шалтгаан нь нийгмийн шилжилт, түүний замбараагүйтэл уран сайхны практик, туурвил зүйд нөлөөлж, нөгөө талаас төрөөс явуулж буй эх хэлний бодлого сул байгаатай холбоотой юм. Гэхдээ уран зохиолын хэлний асуудал нь ээдрээтэй бөгөөд хэлний журам зүйг дээд зэргээр ашиглах боловч уран сайхны үндсэн зорилгодоо хүрэхийн тулд хэлийг эвдэх, үг хэл ярианы дотор ямагт тээгдэн оршиж байдаг дотоод хүчин зүйлс, эрчим хүч, түүний мэдрэмж мэдрэхүй

уншигчдад нөлөөлөх талын сонирхлууд тэргүүн зэрэгт тавигддаг тал бий. Үүний нэлээд тодорхой жишээ нь орчин үеийн хип хоп дуу /энэ их хотын бачимдлын дуун бөгөөд рок роп дуу нь хотын өндөрсөл хийгээд өргөсөлт тэлэлттэй холбоотой үзэгдэл юм.

Аливаа урлагийн хөгжил нь нийгмийн хөгжил, хөдөлгөөн, өөрчлөлттэй гүнзгий барилдлагатай төдийгүй тухайн үндэстний соёл, ёс заншил, уламжлал нь тэрхүү шинэчлэлийн үйл явцаас гадна, гадаад ертөнцийн урлаг соёлын нөлөө, байгаль экологи, хөгжлийн явц чиг хандлага, техник технологийн үйл явцтай шууд холбоотой. Тэрхүү шинэ нийгмийн урлаг, уран сайхан нь тухайн нийгмийнхээ аяг араншин, хэрэгцээ, хүүхэд залуусын хүсэл сонирхол, амьдралын орчин ахуй, өөрчлөгдөж буй үйл явцтай гүн нөхцмөл хам шинжтэй байдаг. Тэр нь аяндаа урлаг, соёл, утга зохиол, яруу найраг, аж төрөх ёсонд нөлөөлж, улмаар хөгжлийн явц хурдац нь шаардлагатай байгаа төрөл жанруудыг аяндаа бий болгодог. Тухайлбал тэргүүн бүлэгт өгүүлсэн сентименталь дуу, “хүрээ дуу”-ны дэлгэрэл нь үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн гялалзсан амжилт, үндэсний тусгаар тогтнолын ялалтаас үүтгэлтэй баяр хөөр, урам хөөр алдагдсантай холбоотой сэтгэлийн гуниг зовлонгоо дугаар илэрхийлж, тэр нь хаа сайгүй бий болсон ууш зуушны газраар дамжин хятад маягийн соёлын нөлөө шингэсэн уйтгар гунигийн аястай дууны баялаг санг бүрдүүлж, XX зууны эхэн үеийн дууны урлагийн хөгжилд нэг шинэ үзэгдэл, шинэ ая данг бий болгон, тэр нь өдгөө үнэ цэнтэй ардын дуу болж хувьссан түүх, түүний дараа хувьсгал ялж нэг зурвас үед хувьсгалын утга чанартай марш дуунууд хүчтэй дэлгэрсэн нь цаг үе, нийгмийн өөрчлөлт, оюун санаа, сэтгэл зүйд хүчтэй нөлөөлж, үндэсний дууны яруу найргийг шинэчлэхэд чухал түлхэц үзүүлсэн билээ.

Баруун европ, америкийн хөгжлийн хурдацыг дагасан урлаг, яруу найргийн хөгжилд цахилгаан хөгжим нэвтэрсэн нь эстрадын болон хип хоп дууны /бачимдал, бухимдал, шүүмжлэл гм/ шинэ төрлүүд, хиппи урлагийн хачин жигтэй хэлбэрүүд үүсэх нөхцөл болж нөгөө талаас нийгмийн бухимдал /шинэ соёлын түрэмгийлэл/, хотжил /өндөр барилга, асфальт зам, үймээн шуугиан, гэрэл гэгээний солигдол, хөгжлийн хурдан хэмнэл/ зэрэг нь хүмүүсийг дөжрөөж, тэр бөгчим орон зайнаас ангижрах, бачимдсан сэтгэлээ илэрхийлэх тийм урлагийн төрөл хэлбэрүүд бий болох нөхцөл болж, тэр нь тухайн нийгмийг бүтээн байгуулж буй шинэ хүмүүст шинэ орон зай, нийцтэй урлагийг бүтээх хүслийн үр дүн болсон ч үндэстний хэлний соёлд нэлээд эвдрэл үүсгэдэг сөрөг нөлөөтэй. Ийнхүү нийгмийн өөрчлөлтийг дагасан соёл, уран сайхны шинэ сэдэл, шинэ үзэгдлүүд аажим алгуур тэрхүү шинэ урлагт дасан зохицох, дараагийн шинэ урлагийн хэлбэрүүд үүсэх хөрс суурь нь болно. Иймээс уламжлалыг үгүйсгэх, хоцрогдсонд тооцож муушаах сэтгэл зүйн сөрөг үзэгдэл нийгэмд буй болж үзэл санааны зөрчил үүсдэг жамтай. Иймээс бид өнөөдөр шинэ урлагийн хэлбэрүүдийг хэрэггүй зүйл гэж яаран үгүйсгэхэд бус, түүнийг үндэсний өвөрмөц онцлог, уламжлалтай холбож хөгжүүлэх боломжийг эрж хайх, урлагийн уран сайхан, уран чадварын өндөр дээд түвшинг уран бүтээлчдээс шаардах эрх нээлттэй юм.

Бид өнөөдөр яг тийм шилжилтийн үеийг туулж байгаа учраас миний болоод түүнээс урагш үеийнхэнд энэ цаг үеийн олон хүчин зүйл таалагдахгүй, “сонгодог уламжлал”-ыг илүүд үзэх, шүтэх, эсвэл залуу үеийнхэнд түүнийг бүтээгчид хуучин мэт төсөөлөл төрүүлж байдаг нь ойлгомжтой зүйл юм. Энэ нь нэг талаас өөрсдийн бий болгосон сонгодог өвийг хамгаалах, нөгөө талаас шинэ үзэгдэлд дасан зохицох чадвар багатайг

харуулдаг юм. Энэ бол урлагийн хөгжлийн уламжлал шинэчлэлийн үйл явцад ямагт тохиолддог зүй тогтол билээ.

Аливаа шинэ зүйлс ямагт шинэ, хачин, гаж, утга учиргүй, үнэт зүйлгүй мэт сэтгэгдэл төрүүлдэг. Улмаар дасан зохицдог. Урлагийн түүхийг үзэхүл үе бүрийн урлаг ямагт ийм л зам мөрөөр л явж ирж. Энэ үйл явцын дунд жинхэнэ шилдэг бүтээл туурвил, түүний өв сан бүрэлдэж, дараагийн шинэчлэл, өөрчлөлтийн ул үндэслэл болж, шинэ хэлбэрүүд үүсэх, түүнийг залгамжлагчдын туурвилаар шинэчлэгдэн баяжихын хамт бидний огт мэдэхгүй, хүлээн авамгүй шинэ урлагийн /яруу найргийн/ бүтээлүүд орон зайгаа олж байдаг. Урлагийн бүтээл бүр ур чадварын харилцан адилгүй түвшинд бүтээгдэж шилдэг нь үлдэж, тааруу бүтээлүүд мартагддаг.

Үүнтэй уялдуулан цаг үе бүрдээ гологддог ая дан зохиогчдод зориулсан захиалгат шүлгүүд олшрон, авъяастай, авъяасгүй хэн дуртай дуучид өөртөө шүлэг тэрлэж, хэн нэг алдарт дуучнаар дуулуулах сонирхол, хоолойндoo таарсан дууны үг өөрөө зохиох, яруу найргийн авъяас багатай шүлэг сонихогчид дууны ая данд булхайгаа нууж яруу найрагт нэр олох, улмаар өөрийн нутаг орон, өөрийн эцэг эх, нэг их гавьдаггүй “хайрт” хурдан морио алдаршуулах гэх зэрэг янз бүрийн хүсэл, зорилго бүхий үйлдэл, эсэн бусын оролдлогууд нь үндэсний хэлний цэвэр ариун байх, яруу найргийн төгс төгөлдөр чанар, монгол хэлний найруулгын уран тансаг зохицол, утга санааны тэнцэтгэл, ая дангийн үндэсний хэв шинжид хүчтэй сөрөг нөлөөлөл, найруулга зүйн тогтсон тааллыг эвдэх үзэгдэл илт мэдрэгдэх болжээ.

SUMMARY

The development of modern Mongolian poetry is commonly described as coinciding with the emergence of revolutionary songs in 1921. Nonetheless, a more interesting and appropriate understanding of 20th-century poetry, and specifically the content and linguistic aspects of song lyrics, may be achieved by studying these as directly connected to the independence movement of 1911 and the conventions of the period that preceded it.